

ГАРЧИГ

НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	3
1.1 Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл	3
1.2 Төсөл хэрэгжих талбайн байриил	3
ХОЁР. ТӨСЛИЙН ХҮЧИН ЧАДАЛ	4
ГУРАВ. ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛӨЛ	6
3.1 Төслийн гол болзошгүй нөлөөлөл Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тухай ерөнхий удирдамж	6
3.2 Төслийн болзошгүй сөрөг нөлөөллийг үнэлэх	6
3.3 Болзошгүй болон гол сөрөг нөлөөллийн үнэлгээний дүгнэлт	7
3.3 Сөрөг нөлөөллийг багасгах, арилгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний зөвлөмж	8
ДӨРӨВ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН	10
4.1 Зорилго	10
4.2 Зорилт	10
4.3 Хамрах хүрээ:	10
4.4 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	11
4.5 Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт	12
4.6 Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний дагуу авах арга хэмжээ	12
4.7 Түүх соёлын дурсгалыг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний дагуу авах арга хэмжээ	12
4.8 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний дагуу авах арга хэмжээ	13
4.9 Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт	13
4.10 Хог хаягдалд авах арга хэмжээний биелэлт	14
4.11 Удирдлага зохион байгуулалт	15
4.12 БОМТ-г хэрэгжилтийн нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь	15
4.13 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, түүний үр дүнг тайлагнах, хэлэлцүүлэх төлөвлөгөө	16
ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ	
Хүснэгт 1 Болзошгүй сөрөг нөлөөлөл байгалийн хам бүрдэлтэй уялдах нь	6
Хүснэгт 2 Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ	8
Хүснэгт 3 2025 оны төлөвлөсөн БОМТ-ний нэгтгэл мөнгөн дүн	10
Хүснэгт 4 Сөрөг нөлөөлөл бууруулах арга хэмжээ	11
Хүснэгт 5 Нөхөн сэргээлтийн үед хэрэгжүүлэх арга хэмжээ	12
Хүснэгт 6 Осол эрсдэлийн арга хэмжээ	13
Хүснэгт 7 Хог хаягдлын арга хэмжээ	14
Хүснэгт 8 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	16
ЗУРГИЙН ЖАГСААЛТ	
Зураг 1 Төслийн талбайн байриил	3

Зураг 2 Шатаах зуухны үйлдвэрийн байр байрших хэсэг	4
Зураг 3 Шатаах зуух байрлах хэсэг баруун талаас	5
Зураг 4 Төслийн талбайн урд хэсэг	5
Зураг 5 Шатаах зуухны хэсэг	5


НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

1.1 Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл

Төслийн нэр:	Аюултай хог хаягдал устгах үйлдвэр
Төсөл хэрэгжүүлэгч:	“Огоот” ХХК
Улсын бүртгэлийн дугаар:	9011059020
Регистрийн дугаар:	2729121
Хаяг, байршил:	Төв аймаг, Сэргэлэн сум, 1-р баг.
Утас:	88119462, 99998297
Ашиглах талбай:	5.85га

1.2 Төсөл хэрэгжих талбайн байршил

Төсөл хэрэгжүүлэх талбай нь Төв аймгийн Сэргэлэн сумын нутаг, 1 дүгээр баг, 4 дүгээр зөрлөгт байршиж үйл ажиллагаагаа явуулахаар төлөвлөсөн. Төслийн талбайн ойр орчимд агуулах болон үйлдвэрийн зориулалт бүхий газрууд байдаг. Төслийн талбай нь 24 цагийн харуул хамгаалалттай, 3 ээлжээр ажилладаг. Аюултай хог хаягдал боловсруулахаас гадна ачаа тээврийн үйлчилгээ үзүүлдэг.



Зураг 1 Төслийн талбайн байршил

ХОЁР. ТӨСЛИЙН ХҮЧИН ЧАДАЛ

Тус төслийн хувьд онцлох төхөөрөмж нь “Аюултай хог хаягдал шатаах зуух” юм. Уг төхөөрөмжийг Монгол улсад “Технологи бридж” ХХК албан ёсоор нийлүүлэлт хийдэг. Итали улсад үйлдвэрлэсэн Lamborghini fire booster тоноглолыг суурилуулсан. Дизель түлшний хамгийн бага хэрэглээтэйгээс гадна бүтэн автомат удирдлагын функцтэй төхөөрөмж юм. Температур тохируулга, агаар галын урсгалыг автоматаар тохируулах систем бүхий олон улсын стандартад нийцсэн байгаль орчны нөлөөллийн хамгийн бага сөрөг үзүүлэлтүүдийг туршилтаар баталгаажуулсан. Биологийн гаралтай хог хаягдлын тухайд үр дүн 100% буюу массыг бүрэн шатааж үлдэгдэлгүй устгана. Бусад хатуу хог хаягдлыг 95 хувь хүртэл бүрэн шатаах боломжтой.

Ажиллах хүчний хувьд тухайн шатаах үйлдвэрлэлд 6 ажилтан ажиллана.

№	Бүтээгдэхүүний нэр	Хүчин чадал	Тоо ширхэг	Түлш зарцуулалт	Шатаалтын хэм	Хаягдлын хэмжээ
1	Шатаах зуух -1000	200-250 кг/цагт	1	7-9 л дизель	800-1200	5% үнс
2	Нам даралтат зуух	366кВт	1	-	-	-
3	Пресслэгч машин	5тн	1	316л гидрийн шингэн	-	-
4	Сэрээт өргөгч	2тн	1	5-10 л дизель	-	-
5	Ачааны машин	33тн	5	50 л/100км	-	-



Зураг 2 Шатаах зуухны үйлдвэрийн байр байрших хэсэг



Зураг 3 Шатаах зуух байрлах хэсэг баруун талаас



Зураг 4 Төслийн талбайн урд хэсэг



Зураг 5 Шатаах зуухны хэсэг

ГУРАВ. ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛӨЛ

3.1 Төслийн гол болзошгүй нөлөөлөл Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тухай ерөнхий удирдамж

Мөв аймгийн Сэргэлэн сумын 1-р багийн нутаг дэвсгэрт байрлах “Аюултай хог хаягдал устгах” төслийн хувьд байгаль орчны төлөв байдал, байгаль орчны эрх зүйн байдал зэрэг нь байгаль орчныг хамгаалах асуудалтай хэрхэн уялдах, төслийн үйл ажиллагаанаас хамрах нутаг дэвсгэрийн орчны бүрдэл хэсгүүдэд төслийн хэрэгжих үе шат бүрийн үйл ажиллагааны нөлөөлөл, түүнчлэн төслийн гол нөлөөллийг үнэлэн тогтоов.

3.2 Төслийн болзошгүй сөрөг нөлөөллийг үнэлэх

Уг төсөл нь төлөвлөлтийн ойрын 5 жилдээ хэрэгжихээр төлөвлөгдсөн ба цаашдаа үргэлжлүүлэн хэрэгжүүлэх бол тухайн үеийн байгаль орчны эрх зүйн асуудлын хүрээнд нэмэлт тодотгол байдлаар нөлөөллийг үнэлэх нь илүү зохистой.

Хүснэгт 1 Болзошгүй сөрөг нөлөөлөл байгалийн хам бүрдэлтэй уялдах нь

№	Нөлөөлөл	Нөлөөллийн эх үүсвэр (үйл ажиллагаа)	Нөлөөллийн шинж чанар, өртөгчдийн байдал
Нэг. Агаар орчин			
1.	Тоосжилт	Тээвэрлэлт	Тархах хүрээ дунд, шороон замаар төслийн талбай хүрдэг.
2.	Дотоод шаталтын хөдөлгүүрийн хорт хий, утаа, угаараас үүдэлтэй агаарын бохирдол	Автомашин	Агаарыг бохирдуулах боловч хадгалагдах болон тархах хүрээ, нөлөөллийн эрчим бага
3.	Шатаах зуухнаас ялгарах утаанаас үүдэлтэй агаарын бохирдол	Шатаах зуух	Шатаах зуух хэвийн бус ажиллагаатай байвал агаар орчин их хэмжээгээр бохирдуулж, нөлөөллийн бүсийн хүн амьтан ургамалд сөрөг нөлөөлнө. Дэлхийн дулааралд дам нөлөө үзүүлнэ.
1.	Нам даралтын уурын зуухнаас гарах утааны бохирдол	Нам даралтат уурын зуух	Нөлөөлөл нь агаар орчин бохирдуулна. Дэгдэмхий үнс хийсэж орчны хөрс ургамалд сөрөг нөлөө үзүүлнэ.
2.	Хүлээн авсан сав баглаа боодлоос химийн бодис уурших ууршилт	Хүлээн авсан химийн хаягдал	Агаарын чанарт сөрөг нөлөө үзүүлнэ. Нөлөөллийн эрчим баг, дам нөлөөтэй. Ил задгай хадгалбал орчны бохирдол, үүсэх эрсдэл өндөр.
Хоёр. Усан орчин			
1.	Хатуу болон шингэн хог хаягдал	Хогийн цэг, хүлээн авсан аюултай хог хаягдал, бохирын цооног дүүрэх	Хөрс болон гүний ус бохирдох магадлал их. Хог хаягдал хур борооны усаар угаагдаж хөрсний ус бохирдуулах магадлалтай.
2.	Гүний ус бохирдох	Үер, их хэмжээний бороо	Үер усны үед ил байгаа хог хаягдал, устгалд оруулах химийн сав баглаа боодол хурын усанд угаагдах, үед орох зэргээс шалтгаалж хөрс бохирдох, цаашлаад гүний усанд сөргөөр нөлөөлөх эрсдэл өндөр
Гурав. Хөрс			
1.	Элэгдэл, эвдрэл	Явган жим, зам гарах, дагтарших, талхлагдах	Хэмжээ хязгаарлагдмал Хөрсний физик, механик шинж чанар өөрчлөгдөхгүй.

№	Нөлөөлөл	Нөлөөллийн эх үүсвэр (үйл ажиллагаа)	Нөлөөллийн шинж чанар, өртөгчдийн байдал
2.	Бохирдол	Ахуйн хог хаягдал, химийн бодисын асаралд гоожилт	Хөрс бохирдсоноос хөрсний микробиологийн болон физик химийн шинж чанар өөрчлөгдөх магадлалтай
Дөрөв. Ургамал бүрхэвч			
1.	Ургамлын талхагдал	Автомашин болон явган хүний зам, мөр	Хэмжээ хязгаарлагдмал
2.	Ургамлын нөмрөг устгах	Автомашин болон явган хүний зам, мөр	Төрөл, зүйл өөрчлөгдөж болно. Төрөл, зүйл устаж болно. Хэмжээ хязгаарлагдмал
3.	Хордолт	Ахуйн хог хаягдал болон химийн бодисын хаягдал	Ургамлын биомассын хэмжээ багасна Ургамлын бүрхэвч эргэлт буцалтгүй устаж болно Ургамлын генд өөрчлөлт орж болно
4.	Талхлагдах	Хүний хөл хөдөлгөөн, химийн бодисын ачилт, буулгалт.	Ургамлын төрөл зүйл өөрчлөгдөж болно. Ургамлыг нөхөн сэргээхэд бэрхшээлтэй болж болно.
Тав. Ан амьтан			
1.	Хордолт	Аюултай хог хаягдал болон ахуйн хаягдал	Хөрсөн дэх бичил биетэн, шавж хорхой үрэгдэж болно.
Зургаа. Нийгэм эдийн засгийн орчин			
1.	Үндсэн хөрөнгө	Татварын эх үүсвэр	Улсын төсөвт хувь нэмэр оруулах
2.	Шинээр ажиллагсад авна	Ажлын байр шинээр бий болно	Орон нутгийн иргэдийн ахуй амьдралд тус дөхөм үзүүлнэ. Тогтмол бус

3.3 Болзошгүй болон гол сөрөг нөлөөллийн үнэлгээний дүгнэлт

Төслийн болзошгүй нөлөөллийн үнэлгээнээс харахад байгаль орчинд төслийн үйл ажиллагаанаас үзүүлэх гол сөрөг нөлөөллийг тодорхойлбол:

- Хүлээн авсан химийн бодисын сав баглаа боодол ил задгай байлгах, агаар устай холилдож орчны хөрс, ус бохирдуулах өндөр эрсдэлтэй.
- Шатаах зуухны хэвийн ажиллагаа доголдсон тохиолдолд агаарыг ихээр бохирдуулах эрсдэлтэй байна.
- Нам даралтат уурын зуухнаас гарах үнсийг ил задгай асгах, эсвэл битүүмжлэлтэй саванд хадгалаагүйгээс салхиар хийсэх, мөн өгөөр орчин бохирдуулах эрсдэлтэй байна.
- Бохирын худаг, цэвэр усны гүний худаг хоорондын зай 50 м-т байгаа нь ундны усны эрүүл ахуйд ноцтой эрсдэл учрахаар байна. Бохирын цооногийн бүрэн бүтэн байдал алдагдвал ундны усны эрүүл ахуйн байдал алдагдаж ажилтнууд цаашлаад төслийн нөлөөллийн бүсийн бусад хүн амд сөрөг нөлөө үзүүлэхээр байна.
- Хийн хаягдал (машин техникээс гарах хий, бодисын ууршилт явагдах үед гарах хий) агаар орчин бохирдуулах
- Байгаль орчны бүрдэл хэсгүүдээс нөлөөлөлд өртөх гол бүрдэл хэсэг нь хөрс, ургамал, агаар байхаар байна. Иймд төслийн зөвлөмжид дурдсан болон хууль эрхзүйн баримт бичгийг байнга мөрдөн ажиллах хэрэгтэй.

Төслийн гол сөрөг нөлөөллийг химийн бодисын сав баглааг хүлээн авахаас эхлэн шатааж устгах, гарсан хог хаягдлыг хууль, журмын дагуу зохицуулах хүртэлх бүхий л үе шатанд авч үзэв. Үүнд богино хугацааных боловч нөхөн сэргээх хугацаа шаардах

нөлөөллүүд, тэдгээрийн эрчим, хамрах хүрээ, хугацаа нь үйл ажиллагааны удирдлага зохион байгуулалтын арга, хэрэглэж байгаа тоног төхөөрөмжийн сонголт зэрэгтэй ихээхэн хамааралтай байна. Төслийн үйл ажиллагааны явц дахь нөлөөлөл нь үйл ажиллагаа эрхлэгчдийн ажлын туршлага, дүрэм журмын хэрэгжилт зэргээс ихээхэн хамаарна.

3.3 Сөрөг нөлөөллийг багасгах, арилгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний зөвлөмж

Төсөл хэрэгжүүлэгч нь төслийн үйл ажиллагаатай холбогдох хууль, дүрэм, журам, стандартын шаардлагыг хангаж ажиллахаас гадна химийн бодисын онцлог шинж чанар, хор аюул, хадгалалт, тээвэрлэлт, ашиглалт талаар ажиллагсдад мэдлэг олгож, болзошгүй сөрөг нөлөөлөл, осол эрсдэлээс урьдчилан сэргийлэх, шаардлагатай тохиолдолд авах арга хэмжээний талаар дотоод дүрэм, журам боловсруулан мөрдөж ажиллах нь зүйтэй.

Хүснэгт 2 Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ

№	Төслийн гол сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг бууруулах арилгах арга хэмжээ
1.	Энгийн хог хаягдлаас үүдэлтэй орчны бохирдол үүсэх. Хог хаягдал ил задгай хаях, хог хаягдлын цэгт ариутгал халдваргүйтгэл хийхгүй байх, тогтмол хугацаанд зайлуулаагүйгээс элдэв шавж үржих, халдварт өвчний эх үүсгэвэр болох	- Зориулалтын тусгай цэг тохижуулах - Тогтсон хугацааны давтамжтай, тогтмол ачин зайлуулах - Хогийн цэгт байнга ариутгал халдваргүйжүүлэлт хийх - Зориулалтын бус газарт шатааж агаар орчин бохирдуулахгүй байх - Ил задгай хаяж орчныг бохирдуулахгүй байх - Эх үүсвэр дээр нь ангилан ялгах - Дахиврыг хэрэглэгч байгууллагад дахин боловсруулахаар шилжүүлэх
2.	Тээврийн хөдөлгөөн ихсэх, хөрс, ургамал талагдах	- Орчны хөрсийг тогтмол цэвэрлэх, нөхөн сэргээх, зүлэгжүүлэх, мод тарих, - Тогтоосон замыг засаж сайжруулах, тэмдэглэгээ хийх, явган хүний зорчих замыг хийж тохижуулж, асфальтаар хучих зэрэг арга хэмжээ авах
3.	Шатаах зуух, хог хаягдлын түр хадгалалтаас агаар ус, хөрс бохирдох	- Үйлдвэр агуулахын агааржуулалтын ажиллагааг байнга хянаж хэвийн ажиллагаатай байлгах, агааржуулалтын систем мембран шүүлтүүртэй байх, тогтмол хугацаанд сольдог байх. - Химийн бодисын сав баглааг хадгалах байрыг битүүмжлэл сайтай байлгах, харуул хамгаалалттай байлгах. - Хадгалах, тээвэрлэх, худалдаалах, ашиглах үеийн аюулгүй ажиллагааны заавар боловсруулан мөрдөж ажиллах - Агуулахыг хариуцсан мэргэжлийн хүн ажиллуулах - Сав баглаанд агуулагдаж байсан бодисын хор аюулын талаарх мэдээлэл, танилцуулах самбар тэмдэг тэмдэглэгээг агуулахад ил байршуулах - Гадаргын болон газрын доорх усанд алдахгүй байх
4.	Химийн бодист өртөх, хүн амьтанд хортой аюултай нөлөө үзүүлэх	- Химийн ШҮ, химийн бодисын талаар суралцсан мэргэжлийн хүн ажиллуулах - Бодисын хор аюул, нөлөөллийн талаарх мэдээ мэдээлэл өгөх сургалт байнга зохион байгуулах - Байгальд ил задгай хаяхгүй байх - Бодистой ажиллах үеийн аюулгүй ажиллагааны зааварчилгааг өдөр бүр өгөх - Зааварчилгаа, дүрэм журмыг мөрдөн ажиллаж байгаа эсэхэд хяналт тавих

№	Төслийн гол сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг бууруулах арилгах арга хэмжээ
		- Болзошгүй осол эрсдэлээс ямагт урьдчилан сэргийлж анхаарал болгоомжтой ажиллах, эрсдэл тохиолдсон үед хэрэглэх хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэглэл, гал унтраах багаж хэрэгслийг бэлэн байлгах.
5.	Химийн бодисоор бохирдсон хортой, аюултай хог хаягдал гарах	- Аюултай хог хаягдал үүсгэгчийн код авах - Хог хаягдлын тухай хуулийг мөрдөж ажиллах - Химийн бодисын сав баглаа боодлыг худалдан авагч нараасаа тоо ширхгээр нь буцаан татан авч түр хадгалах. - Аюултай хог хаягдал цуглуулж түр хадгалах тусгай цэг, хадгалах агуулах бий болгож хяналттай байлгах - Химийн бодисоор бохирдсон материал, эд зүйл, хугацаа дууссан бодис урвалж зэрэг аюултай хог хаягдлыг ангилан хадгалах - Бохирдсон бүх зүйлийг тусгайлсан хогийн цэгт түр хадгалах - Аюултай хог хаягдлыг хуульд заасны дагуу хэмжээнээс хамааран 90 хоног хүртэл хадгалах - Эрх бүхий тусгай зөвшөөрөлтэй байгууллагатай эрх шилжүүлэх гэрээ хийх, дагалдах маягт бүртгэлийг хөтөлж бүртгэх - Эрх шилжүүлэхдээ дагалдах бичиг баримтыг бүрдүүлж ажиллах - Аюултай хог хаягдлын тайланг жил бүрийн 11 сард гаргаж харьяа дүүргийн Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэст албан тоотоор хандан хүргүүлэх - Дээрх үйл ажиллагаануудын хууль эрх зүйн үндсийг доор тусгав. Үүнд: - Хог хаягдлын тухай хууль /шинэчилсэн найруулга/ - Аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах болон бүртгэх, тайлагнах журам /2018, 116-р тогтоол 1 дүгээр хавсралт/
6.	Химийн бодисын сав баглаа боодлын тээвэрлэлт, түүнтэй холбоотой аюул эрсдэл гарах /гэнэтийн осол аваар, техникийн бүрэн бус байдал, жолоочийн хариуцлагагүй байдал/	- Тус төлөвлөгөөнд “Асгаралд бага үед авах арга хэмжээ, саармагжуулах арга”, “Бодисын асгаралд их үед авах арга хэмжээ, саармагжуулах арга”-ыг тус тус нарийвчлан тусгаж өгөх, харьяа дүүргийн ОБГ-аар шинэчлэн хянуулж батлуулах. - Тогтоосон маршрутаас ангид тээвэр хийхийг хатуу хориглох - MNS 4978:2017 Аюултай ачаа. Ангилал. Тээвэрлэлтэд тавих ерөнхий шаардлагыг хангасан тээврийн хэрэглэлээр тээвэрлэлтийг хийх - Аюултай ачаа тээвэрлэх тусгай зөвшөөрөл авах - Дадлага туршлагатай тээврийн ангилалд нийцсэн жолоочийг химийн бодисын аюул эрсдэлээс сэргийлэх сургалтад хамруулсны дараа химийн бодисыг тээвэрлэх тээвэрт явуулах - Өөрсдөө тээвэр хийх боломжгүй тохиолдолд тусгай зөвшөөрөл бүхий тээвэрлэлтийн компаниар тээвэрлэлтийг гүйцэтгүүлэх.

“Химийн хорт болон аюултай бодисын тухай” хуулийн холбогдох заалтууд, Монгол Улсын Шадар сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Эрүүл мэндийн сайдын 2017 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн 54/А/136/А/215 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам” байгаль орчны сайд, Эрүүл мэндийн сайдын 2003 оны 126/171 дугаар хамтарсан тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан “Химийн бодисын хаягдлыг байгаль орчинд халгүй цуглуулах, хадгалах, тээвэрлэх, устгах технологийн аргачилсан заавар”-тай танилцаж мөрдөн ажиллах шаардлагатай.

Мөн Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй, Химийн хорт болон аюултай бодис, бүтээгдэхүүний агуулахын Ерөнхий шаардлага MNS:6458:2014 стандарт зэргийг баримтлан ажиллах шаардлагатай.

ДӨРӨВ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

4.1 Зорилго

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутагт дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилготой.

4.2 Зорилт

1. БОЕУ-гээр дүгнэгдсэн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах арга хэмжээнүүдийг шат дараатай авч ажиллах
2. Нутгийн уугуул иргэдтэй нээлттэй харилцаж, байгаль орчинд халгүй нөхцөлийг бүрдүүлж хамтран ажиллах
3. Мэдээллийн ил тод байдлыг хангаж, нутгийн иргэд болон засаг захиргааны нэгжүүдтэй нягт уялдаатай ажиллах зорилтуудыг тавьж ажиллана.

4.3 Хамрах хүрээ:

Манай төслийн хувьд хамрах хүрээгээ өөрийн төсөл хэрэгжих газар талбайд төдийгүй, харьяа нутаг дэвсгэрийн ус, хөрс, ан амьтан хамгаалах, үргэж зайлахаас сэргийлэн ажиллахаар төлөвлөж байна.

Хүснэгт 3 2025 оны төлөвлөсөн БОМТ-ний нэгтгэл мөнгөн дүн

Д/д	Бүрэлдэхүүн хэсгүүд	Тухайн жилийн зардал /мян.төг/	Гүйцэтгэл, мян.төг
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	8,500.0	20,770.0
2	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө /ногоон байгууламжийн төлөвлөгөө/	700.0	-
3	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-	-
4	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	-	-
5	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-	-
6	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	680.0	1,464.0
7	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	480.0	577.2
8	Удирдлага зохион байгуулалт	-	-
9	БОМТ-г хэрэгжилтийн нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь	-	-
10	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	345.0	1,950.3
Нийт		10,705.0	24,761.5

4.4 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Хүснэгт 4 Сөрөг нөлөөлөл бууруулах арга хэмжээ

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Нэгжийн зардал, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Гүйцэтгэл, мян.төг	Хийгдсэн ажлын тайлбар
	1	2	3	5	6	7	8	9
1	Агаарын чанар	Агаарын бохирдол үүсгэхгүй байх үүднээс түүхий нүүрс түлэхгүй байх, сайжруулсан түлш хэрэглэх	Төслийн талбайд	-	-	-	-	Төвлөрсөн бүсээс хол болохоор түүхий нүүрс түлж байгаа. Баян тээгийн уурхайн нүүрийг худалдан авдаг.
2		Шатаалтаас гарах үнсийг тусгайлан хадгалах битүүмжлэлтэй савтай байх, ахуйн хог хаягдлаас тусад нь хадгалах	Төслийн талбайд	500.0	1	500.0	ҮАЗ-аар	Шатаалтаас гарах үнсийг тусгайлан хадгалах битүүмжлэлтэй савтай ба ахуйн хог хаягдлаас тусад нь хадгалдаг. Үнс авах бүрд болон 7 хоногт 3-5 удаа ариутгал хийгдэж байна.
3	Хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөг	Шатаах хэсгийг үйлдвэрийн байрын барилгыг сайжруулах, хаалт, хаалгатай болгох	Төслийн талбайд	8,000.0	1	8000.0	-	Шатаах хэсгийг үйлдвэрийн байрын барилгыг сайжруулалт, заагдсан хаалт, хаалгатай болгосон хашаалж, битүүлэн дотор хэсгийг бетондсон
4	Гадаргын ба газрын доорх усны нөөц	Төслийн хашаа доторх зам талбайд тоосжилт үүсэхээс сэргийлж явган хүний зам, авто машины зам, зогсоолыг хатуу хучилттай болгож тохижуулах.	Төслийн талбайд	-	-	-	20,770.0	Хөрсөнд бохирдол алдахгүй зорилгоор төслийн талбайд өргөн-40м, урт-80м буюу 1040м ² газрыг бетон хашаагаар битүүлж.
5		Ахуйн хог хаягдлын цэгийг тохижуулах	Төслийн талбайд	-	-	-	-	Дотоод нөөц боломжоороо ахуйн хог хаягдлыг тохижуулж сайжруулж ажиллаж байгаа
6	Газрын хэвлий	-	-	-	-	-	-	-
Нийт						8500.0	20,770.0	

4.5 Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт

Хүснэгт 5 Нөхөн сэргээлтийн үед хэрэгжүүлэх арга хэмжээ

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ /ш/	Нэгжийн зардал, мян/төг	Нийт зардал, мян/төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Гүйцэтгэл, мян.төг	Хийгдсэн ажлын тайлбар
	1	2	3	4	5	6	7	8	9
1	Нөхөн сэргээлт	“Тэрбум мод үндэсний хөдөлгөөн”, Төв аймгийн байгаль орчны газрын чиглүүлэгээр эсвэл харьяа сумын захиргаатай зөвшилцөн заасан талбайд мод тарих	ш	20	35.0	700.0	Жилдээ	Группээс нэгдсэн журмаар өгсөн.	Сумын байгаль орчны байцаагчтай зөвшилцөн шатаах зуухны хашааны дотор талбайд 30ш мод тарьсан. Группээс нэгдсэн журмаар өгсөн.
2		Төслийн талбай орчны тохижилт, цэвэрлэгээнд анхаарах, эзэмшил талбайн гаднах 50м радиуст цэвэрлэгээ хий, тэмдэг тэмдэглэгээг засах, сайжруулах.	тухай бүр	-	-	-	Тогтмол	-	Баазын хашаанд 7 хоног бүрийн 5 дахь өдөр цэвэрлэгээ хийж сард 1 удаа их цэвэрлэгээ хийдэг
Нийт						700.0		-	

4.6 Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний дагуу авах арга хэмжээ

Тухайн төсөл хэрэгжих газар нь Төв аймгийн Сэргэлэн сумын нутаг дэвсгэрт байрлах ба төслийн чиглэл, хүчин чадал, үйл ажиллагаатай холбоотойгоор хүн амыг нүүлгэх шаардлагагүй юм.

4.7 Түүх соёлын дурсгалыг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний дагуу авах арга хэмжээ

Төсөл хэрэгжүүлэгчийн үйл ажиллагаа явуулж буй тус газар нь суурин бүсэд байрладаг. Тухайн талбайд түүх соёлын дурсгалт зүйл илрээгүй бөгөөд төслийн хэрэгжилтийн үед түүх соёлын дурсгалт зүйл илэрсэн тохиолдолд харьяалах орон нутгийн байгаль орчны газар, соёлын өв хариуцан ажиллаж буй ажилтан албан байгууллагад хандан мэдэгдэх үүрэг хүлээнэ.

4.8 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний дагуу авах арга хэмжээ

Төсөл хэрэгжүүлэгч “Огоот” ХХК нь “Аюултай хог хаягдал устгах үйлдвэр” төслөөс үүсэж буй хог хаягдлаас байгаль орчин, хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийг бага хэмжээнд байлгахаар төлөвлөх нь зүйтэй бөгөөд хөрсийг бохирдуулахгүйн тулд хог хаягдлыг түр хадгалах цэгт ангилан битүүмжлэлтэй саванд байршуулах, энэ талаар зохих мэдлэгийг ажиллагсад өгч ажиллах нь зүйтэй юм.

4.9 Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт

Хүснэгт 6 Осол эрсдэлийн арга хэмжээ

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, мян.төг	Нийт зардал, мян.төг	Гүйцэтгэл, мян.төг	Хийгдсэн ажлын тайлбар
	1	2	3	4	5	6	8	9
1	Болзошгүй осол, саатал, техник технологийн шугам сүлжээний гэмтэл, галын гэнэтийн аюул үүсэх	Тоног төхөөрөмжийн үзлэг оношилгоо хийлгэж, аюулгүй байдалд хяналт тавих, аюулгүй байдлаа хангаж ажиллах, баримтжуулах.	Төслийн хүрээнд	Тухай бүр	-	-	ҮА зардлаар	Тоног төхөөрөмжийн үзлэг оношилгоо хийлгэж, аюулгүй байдалд хяналт тавьж, аюулгүй байдлаа хангаж ажилладаг
2		Төслийн талбайд гал унтраах багаж хэрэгсэл бүрэн байрлуулах, сэрэмжлүүлэх тэмдэглэгээ, самбар зэргийг ил байршуулах	Төслийн хүрээнд	1	500	500	726.0	Төслийн талбайд гал унтраах багаж хэрэгсэл бүрэн байрлуулах, сэрэмжлүүлэх тэмдэглэгээ, самбар зэргийг ил байршуулсан
3		Ажилтныг хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн хувцас, хамгаалах хэрэглэлээр хангаж ажиллах	Төслийн хүрээнд	3хүн * 6 сар	20	180	738.0	Ажилтныг хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн хувцас, хамгаалах хэрэглэлээр хангаж ажиллаж байна
4		Гамшгаас хамгаалах төлөвлөгөө батлуулах	Төслийн хүрээнд	Тухай бүр	-	-	ҮА зардлаар	Гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулж, батлуулсан
Нийт						680.0	1,464.0	

4.10 Хог хаягдалд авах арга хэмжээний биелэлт

Хүснэгт 7 Хог хаягдлын арга хэмжээ

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Гүйцэтгэл, мян.төг	Хийгдсэн ажлын тайлбар
	1	2	3	4	5	6	7	8	9
1	Хог хаягдал	Ахуйн хатуу хог хаягдлыг гэрээний дагуу ачин зайлуулж байх	Төслийн хүрээнд	удаа	160.0	3	480.0	577.2	Ахуйн хог хаягдлыг Налайх дүүргийн хот тохижуулах газартай гэрээ хийж ачуулж байгаа
2		Нам даралтат зуухнаас гарах үнсийг тусгайлан битүүмжлэлтэй саванд хадгалах, ачуулах	Төслийн хүрээнд	удаа	500.0	10	500.0	-	Зориулалтын өөрөө буулгагч автомашинаар зөөвөрлөж хаядаг
3	Аюултай хог хаягдал	Аюултай хог хаягдал буюу сав баглаа боодол шатаалтаас гарах үнсийг тусгайлан битүүмжлэлтэй, хаягжуулан хадгалах	Төслийн хүрээнд	-	-	-	ҮА зардлаар	ҮА зардлаар	Аюултай хог хаягдлаас гарч байгаа үнсийг тагтай битүүмжилсэн 200-ийн саванд хийж хаягжуулан хадгалж байна. Дотоод нөөц бололцоогоо ашигласан.
4		Аюултай хог хаягдлаас гарах үнсийг тусгай эрх бүхий 1 дүгээр зэргийн ландфиль үүсгэх эрх бүхий аж ахуй нэгжид хүлээлгэн өгөх	Төслийн хүрээнд	-	-	-	Тухайн ачилт бүрээр үнэ тооцох	-	Аюултай хог хаягдлаас гарч байгаа үнсийг одоогоор хадгалж байгаа. 1-р зэргийн ландфиль хийх тусгай эрх бүхий байгууллага олдоогүй. Цэцүүх ХХК болон Элемент ХХК-үүд одоогоор авахгүй, үйл ажиллагааг эхлүүлэхээр авах төлөвлөгөөтэй гэж мэдэгдсэн.
5		Аюултай хог хаягдлын дагалдах бичиг баримтыг бүрдүүлэн ажиллах	Төслийн хүрээнд	-	-	-	ҮА зардлаар	-	Аюултай хог хаягдлын дагалдах бичгийг тухай бүр бүртгэж баримтжуулан хадгалж явдаг
Нийт							980.0	577.2	

4.11 Удирдлага зохион байгуулалт

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь			Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
			2025 он				
			Сар 4	Сар 5	Сар 6		
			1	2	3	4	5
1	Төслийн үйл ажиллагааны хүрээнд ХАБЭА-н дотоод журамтай байх.	-	-	Журам боловсруулан батлах, журамтай бол сайжруулах.	-	Захирал	ХАБЭА-н журамтай, журмаа хэрэгжүүлэн ажиллаж байна.
2	Аюултай хог хаягдал боловсруулах үйлдвэрийн технологийн заавартай байх	-	-	-	✓	Захирал	

4.12 БОМТ-г хэрэгжилтийн нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь

№	БОХТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, /мян.төг/	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Тайлбар
	1	2	3	4	5	6	7
1	Сумын засаг даргад	Албан бичиг, цаасан тайлангийн хамт	БОМТ-ний биелэлтийн тайлан	Тайлант жилийн 10-р сарын 25	--	Байгаль орчны асуудал хариуцсан ажилтан	Холбогдох төрийн байгууллагад албан тоотоор хүргүүлж ажиллав.
2	Аймгийн байгаль орчны газарт	Албан бичиг, цаасан тайлангийн хамт	БОМТ-ний биелэлтийн тайлан	Тайлант жилийн 11-р сарын 10-ны дотор	--	Байгаль орчны асуудал хариуцсан ажилтан	
3	БОУАӨЯ-ны ХБОБНУГ-т	Цахим тайлан	БОМТ-ний биелэлтийн тайлан	Тайлант жилийн 12 дугаар сар	--	Байгаль орчны асуудал хариуцсан ажилтан	
	Нийт				-		

4.13 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, түүний үр дүнг тайлагнах, хэлэлцүүлэх төлөвлөгөө

Хүснэгт 8 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналт цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг /мян.төг/	Гүйцэтгэл, мян.төг	Тайлбар	Баримтлах арга, аргачлал, стандарт, шаардлагууд
	1	2	3	4	5	6		7	8
Агаарын чанар									
1.1	Агаарын бохирдлын (NO2, SO2, CO) шинжилгээ хийлгэж байх /БОТЛ мэргэжилтэн хөлслөн хийлгэнэ/	Төсөл хэрэгжих талбайд хяналтын 1-2 цэг сонгох.	жилд 1 удаа	1	35.0	35.0	1,793.0	Шинжилгээ хийгдэж стандарт шаардлага хангасан	Ногоон титэм лабораториор яндангийн утааны шинжилгээ хийлгэсэн. Цаашид гэрээлэн ажиллах юм. Агаар орчны шинжилгээний хариу байвал зохих хэмжээнд гарсан байна.
1.2	Агаарын тоосны (TSP, PM10, PM2.5) шинжилгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэх		жилд 1 удаа	1	35.0	35.0			
1.3	Дуу шуугиан, чичиргээ: үйлдвэрийн тоног төхөөрөмжийн орчим		жилд 1 удаа	1	35.0	35.0			
Усны хяналт шинжилгээ									
2.1	Унд ахуйн цэвэр усны шинжилгээ – /Хими, микробиологи, хүнд металл/	Ундны уснаас дээжлэх	жилд 1 удаа	1	95.0	95.0	80.0	Хийгдсэн хэвийн	Инженер геодези ХХК
Хөрсний бохирдол									
3.1	Хөрсний шинжилгээ – Агро хими	Хогийн цэг орчмоос 1, Шатаах үйлдвэрийн хашаанаас 1	Жилд 1 удаа	Жилд 1 удаа	45.0	45.0	77.3	Үзүүлэлт хэвийн стандарт хангасан	Инженер геодези ХХК
3.2	Хөрсний шинжилгээ – Хүнд металл /6 үзүүлэлт/				85.0	85.0			
3.3	Хөрсний шинжилгээ – Механик бүрэлдэхүүн				15.0	15.0			
Амьтны аймаг									
4.1	Амьтны аймаг	-	-	-	-	-	-	-	
Гүйцэтгэл						345.0	1,950.3		

ДҮГНЭЛТ

“Огоот” ХХК нь “Аюултай хог хаягдал устгах үйлдвэр” төслийн 2025 оны төлөвлөгөөний сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээнд 8,500,000.0 төгрөг, нөхөн сэргээлтийн төлөвлөгөөнд 700,000.0 төгрөг, осол эрсдэлийн төлөвлөгөөнд 680,000.0 төгрөг, хог хаягдлын төлөвлөгөөнд 480,000.0 төгрөг, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт 345,000.0 төгрөг нийт **10,705,000.0** төгрөг зарцуулахаар төлөвлөсөн. Ажлын гүйцэтгэлийн дээрх тайлангаар хүргүүлж байна.

Гүйцэтгэлд нийт 24,761,000.0 төгрөг зарцуулсан байна.

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Хийгдсэн ажлын тайлбар	Зураг		
	1	8	9		
1	Агаарын чанар	Шатаалтаас гарах үнсийг тусгайлан хадгалах битүүмжлэлтэй савтай ба ахуйн хог хаягдлаас тусад нь хадгалдаг. Үнс авах бүрд болон 7 хоногт 3-5 удаа ариутгал хийгдэж байна.			
2	Хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөг	Шатаах хэсгийг үйлдвэрийн байрын барилгыг сайжруулалж заагдсан хаалт, хаалгатай болгосон хашаалж, битүүлэн дотор хэсгийг бетондсон			

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Хийгдсэн ажлын тайлбар	Зураг		
	1	8	9		
3	Гадаргын ба газрын доорхи усны нөөц	Хөрсөнд бохирдол алдахгүй зорилгоор төслийн талбайд өргөн-40м, урт-80м буюу 1040м ² газрыг бетон хашаагаар битүүлж.			
					
4		Дотоод нөөц боломжоороо ахуйн хог хаягдлыг тохижуулж сайжруулж ажиллаж байгаа			


Мод тарьсан байдал



Орчны цэвэрлэгээ




Тоног төхөөрөмжийн үзлэг оношилгоо хийлгэж, аюулгүй байдалд хяналт тавих, аюулгүй байдлаа хангаж ажиллах, баримтжуулах.



№	Авсан арга хэмжээ	Хийгдсэн ажлын тайлбар	Зураг
	1	2	3
